



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГА  
Ц.ЖАДАМБАА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.22 № 08/24 УАТ-САТ/2013/19-САТ-ТТЗ

**ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ**

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын 2012 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Тус газрын харилцах данснаас 2012 онд гадаад, дотоод томилолтод 28,059,55/20 төгрөгийг шилжүүлэхдээ авлагын дансаар дамжуулаагүй, зарцуулалтын нотлох баримт дутуу байхад шууд зардлын дансанд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Мөн тус газрын харилцах данснаас 2012 оны 12 дугаар сарын 10-д Магнайтрейд ХХК-д шатахууны талоны үнэнд 5,0 сая төгрөг шилжүүлсэн боловч түүнийг материалын дансанд орлого авч, зарцуулалт гаргаагүй, зарцуулалтын нотлох баримтгүй байхад шууд зардлын дансанд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих” гэж заасныг үндэслэн дээрх зардлын нотлох баримтыг холбогдох ажилтнуудаас гаргуулан авч зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг гарган 2013 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус газрын Ерөнхий нягтлан бодогч Б.Бямбасүрэнд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:**

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР**

Ц.Жадамбаа  
УХА0122

**Л.ОДГЭРЭЛ**

**ЗӨВШӨӨРСӨН:**

**МТШХХГ-ЫН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ**

Б.Бямбасүрэн  
УХА0122

**Б.БЯМБАСҮРЭН**

070100